

## Ус, намгархаг газрын дэлхийн өдөр

Written by Administrator

Thursday, 02 February 2017 09:09

There are no translations available.



1971 оны 2 дугаар сарын 2-ны одор Иран улсын Рамсар хотноо Каспийн тэнгисийн эрэгт “Ус намгархаг газрын тухай конвенц”-ийг баталсан тул энэ одрийг Ус чийг, намгархаг газрын дэлхийн одор болгон жил бүр тэмдэглэдэг уламжлал тогтжээ.

Монгол улс энэхүү конвенцид 1998 оны 4 сарын 8-ны одор албан ёсоор нэгдэн орсон боогоод конвенцийн вйл ажиллагаанд тогтмол оролцож ирсэн болно. “Рамсарын жагсаалт”-д манай орны 11 газар-Огийнуур (1998он), Монгол Дагуур (1997), Тэрхийн Цагаан нуур (1998), Нууруудын хондийн нуурууд (1998), Хар-Уснуур (1999), Айрагнуур (1999), Ачитнуур түүний орчмын ус, намгархаг газар (2004), Буйрнуур, түүний орчмын ус, намгархаг газар (2004), Гангануур, түүний орчмын ус, намгархаг газар (2004), Увснуур, түүний орчмын ус, намгархаг газар (2004) Хурх, Хвйтэн голын хондийн нуурууд (2004) бүртгэлтэй.

Ус, намгархаг газрын дэлхийн одор, "Олон Улсын ач холбогдол бүхий ус, намгархаг газар, ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчны тухай конвенц /Рамсар/", Монгол орны рамсарын конвенцэд бүртгэлэй нууруудын талаар орон нутгийн радиогоор дамжуулан ард иргэдийг мэдээллээр хангав.